



СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,
ДОТООД АУДИТЫН ГАЗАР
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 07 сарын 25 өдөр

Дугаар СХШ-2025/19

Сүхбаатар сум

Орхонтуул сумын Засаг даргын Тамгын
Газрын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн
хяналт шалгалтын дүн

**Нэг: Хяналт шалгалтын зорилго, хамарсан хүрээ, хугацаа, шалгуулсан
байгууллагын чиг үүрэг, зохион байгуулалт**

1.1. Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын даргын баталсан 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 17 дугаартай "Санхүүгийн хяналтын ажлын удирдамж"-аар Орхонтуул сумын Засаг даргын Тамгын газрын санхүү төсвийн гүйцэтгэл болон Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хуулиуд болон Монгол Улсын холбогдох бусад хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан эрх зүйн актуудын хэрэгжилтийг хянан шалгах, илэрсэн зөрчил дутагдалд дүгнэлт өгөх засаж залруулах зорилготойгоор хяналт шалгалт хийлээ.

1.2. Шалгалтыг Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын СХШУАБ Т. Мөнхзул 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрөөс 2025 оны 07 дугаар сарын 25-ны өдрийг дуустал хийж гүйцэтгэлээ.

1.3. Шалгалтад Орхонтуул сумын Засаг даргын Тамгын газрын (цаашид Орхонтуул сумын ЗДТГ гэх)-ын 2023, 2024 онуудын санхүү, төсвийн гүйцэтгэл болон үйл ажиллагааны баримт материал, тайлан тооцоог хамруулав.

1.4. Орхонтуул сумын ЗДТГ нь улсын бүртгэлийн 9056335 дугаар регистртэй, Төрийн сан дах үндсэн үйл ажиллагааны 100131055001 дугаартай данс, нэмэлт санхүүжилтийн 100131055401 дугаартай дугаартай данснуудыг ашиглаж байна.

1.5. Орхонтуул сумын Төсвийн орлого зарлага, тайлагналт, Төрийн сангийн харилцах дансанд 1-р гарын үсгийг сумын ЗДТГ-ын дарга Д.Мэнд-Амар, 2-р гарын үсгийг нягтлан бодогч Б.Хоролсүрэн нар зурж төсвийн хөрөнгийг захиран зарцуулж байна.

1.6. Орхонтуул сумын ЗДТГ нь улс төрийн албан тушаалтан 2, төрийн захиргааны албан хаагч 9, төрийн үйлчилгээний бусад албан хаагч 10 нийт 21 хүний орон тоогоор үйл ажиллагаа явуулж байна.

Хоёр. Шалгалтад хамрагдах асуудлууд

2.1 Санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж, засгийн газрын шийдвэр болон түүнийг үндэслэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан заавар, журмын хэрэгжилт

2.1.1 Байгууллагын хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт 87.9 хувь, Сэлэнгэ аймгийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээний биелэлт 73.1 хувь хэрэгжүүлсэн байна.

2.1.2 Сумын ЗДТГ нь санхүүгийн үйл ажиллагааг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад санхүүгийн хууль тогтоомжийн хүрээнд УСНББОУС, Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг мөрдлөг болгон нягтлан бодох бүртгэлийг хөтлөн явуулж байгаа боловч тэдгээртэй холбоотой хуулийн тогтоомж зөрчих үйлдэл оршсоор байна.

2.2. Батлагдсан төсөв, гүйцэтгэл зориулалтын дагуу зарцуулсан байдал

2.2.1 Батлагдсан төсөв:

2023 онд орон нутгийн төсвөөс 783,598.9 мянган төгрөгөөр 2024 онд 1,179,041.8 мянган төгрөгөөр санхүүжихээр төсөв батлагдсанаас 2023 онд 584,901.6 мянган төгрөгийг буюу 74.6 хувийг, 2024 онд 994,057.9 мянган төгрөгийг буюу 84.3 хувийг тус тус зарцуулсан байна.

Хүснэгт 1

/мян.төгрөгөөр/

	Үзүүлэлт	2023 онд			2024 он		
		Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	хэмнэлт/+/ хэтрэлт /-/	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	хэмнэлт/+/ хэтрэлт /-/
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	783,598.9	584,901.6	198,697.3	1,179,041.8	994,057.9	184,983.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	616,998.9	530,147.9	86,851.0	1,066,809.7	883,891.0	182,918.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	615,567.0	530,147.9	85,419.1	1,045,089.7	862,334.4	182,755.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	377,445.6	357,221.2	20,224.4	738,219.5	624,551.2	113,668.3
210101	Үндсэн цалин	233,847.6	214,279.4	19,568.2	269,352.6	271,101.6	-1,749.0
210102	Нэмэгдэл	143,598.0	94,787.5	48,810.5	359,234.8	262,565.8	96,669.0
210104	Урамшуулал	0.0	9,277.8	-9,277.8	0.0	11,580.3	-11,580.3
210105	Гэрээт ажлын хөлс	0.0	38,876.4	-38,876.4	109,632.1	79,303.5	30,328.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	47,180.8	45,284.2	1,896.6	92,277.5	77,784.7	14,492.8
210201	Тэтгэврийн даатгал	32,083.1	30,817.0	1,266.1	62,748.7	60,137.6	2,611.1
210202	Тэтгэмжийн даатгал	3,774.4	3,660.2	114.2	7,382.2	6,208.3	1,173.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,019.5	2,883.6	135.9	18,455.5	8,287.2	10,168.3

210204	Ажилгүйдлийн даатгал	754.9	714.5	40.4	3,691.1	3,151.7	539.4
210205	Эрүүл мэндийн даатгал	7,548.9	7,209.0	339.9	0.0	0.0	0.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	51,005.8	49,005.8	2,000.0	54,241.7	50,075.2	4,166.5
210301	Гэрэл, цахилгаан	6,992.7	6,992.7	0.0	8,239.6	8,178.9	60.7
210302	Түлш, халаалт	42,712.3	40,712.3	2,000.0	44,801.3	40,695.5	4,105.8
210303	Цэвэр, бохир ус	1,300.8	1,300.8	0.0	1,200.8	1,200.8	0.0
210304	Байрны түрээс	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
2104	Хангамж, бараа материалын зардал	22,101.4	15,721.5	6,379.9	32,711.2	30,109.8	2,601.4
210401	Бичиг хэрэг	3,977.0	1,360.6	2,616.4	3,405.4	3,846.5	-441.1
210402	Тээвэр, шатахуун	13,571.5	10,200.0	3,371.5	22,527.0	20,680.0	1,847.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,072.0	2,711.6	360.4	4,155.4	3,099.0	1,056.4
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,480.9	1,449.4	31.6	2,623.4	2,484.3	139.1
2105	Нормативт зардал	512.4	270.0	242.4	581.1	581.1	0.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	512.4	270.0	242.4	581.1	581.1	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	26,131.3	6,152.5	19,978.8	15,355.0	11,874.0	3,481.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,777.0	0.0	6,777.0	4,044.7	1,880.0	2,164.7
210602	Тавилга	8,692.8	0.0	8,692.8	0.0	0.0	0.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	661.5	661.5	0.0	809.9	618.3	191.6
210604	Урсгал засвар	10,000.0	5,491.0	4,509.0	10,500.4	9,375.7	1,124.7
2107	Томилолт, зочны зардал	4,957.2	4,077.9	879.3	6,637.6	6,350.2	287.4
210701	Гадаад албан томилолт	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
210702	Дотоод албан томилолт	4,957.2	4,077.9	879.3	6,637.6	6,350.2	287.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,312.1	12,597.0	4,715.1	47,160.7	19,168.1	27,992.6
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,673.2	12,245.4	2,427.8	43,008.0	16,539.9	26,468.1
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	226.4	0.0	226.4	338.5	0.0	338.5
210803	Даатгалын үйлчилгээ	603.0	0.0	603.0	1,001.2	681.5	319.7
210804	Тээврийн хэрэгслийн татвар	420.3	107.2	313.1	537.5	531.9	5.6
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	196.5	0.0	196.5	302.3	302.3	0.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	712.6	237.6	475.0	1,086.0	1,086.0	0.0

210807	Газрын төлбөр	453.6	6.9	446.7	697.5	26.5	671.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	26.5	0.0	26.5	189.7	0.0	189.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	68,920.4	39,817.6	29,102.8	57,905.4	41,840.1	16,065.3
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	68,328.1	39,225.3	29,102.8	56,743.2	40,872.9	15,870.3
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	592.3	592.3	0.0	1,162.2	967.2	195.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,431.9	0.0	1,431.9	21,720.0	21,556.7	163.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,431.9	0.0	1,431.9	21,720.0	21,556.7	163.3
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	0.0	0.0	0.0	21,720.0	21,556.7	163.3
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,431.9	0.0	1,431.9	0.0	0.0	0.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	166,600.0	54,753.7	111,846.3	112,232.1	110,166.8	2,065.3
220001	Барилга байгууламж	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
221001	Их засвар	134,600.0	22,753.7	111,846.3	112,232.1	110,166.8	2,065.3
222001	Тоног төхөөрөмж	32,000.0	32,000.0	0.0	0.0	0.0	0.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	783,598.9	584,901.6	198,697.3	1,179,041.8	994,057.9	184,983.9
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	544,561.6	584,401.6	-39,840.0	1,178,541.8	993,557.9	184,983.9
320001	Орон нутгийн төсвөөс	544,561.6	584,401.6	-39,840.0	1,178,541.8	993,557.9	184,983.9
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	239,037.3	500.0	238,537.3	500.0	500.0	0.0
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	500.0	500.0	0.0	500.0	500.0	0.0
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	238,537.3	0.0	238,537.3	0.0	0.0	0.0

Төсвийн гүйцэтгэлийн судалгаанаас зарцуулалтыг зардлын ангилал бүрээр шалгаж дүгнэхэд:

1. **Цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал:** нийт төсвийн 2023 онд 377,445.6 мянган төгрөг 2024 онд 738,219.5 мянган төгрөгийг цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалд олгохоор төсөвлөснөөс 2023 онд 357,221.2 мянган төгрөгийг зарцуулж 20,224.4 мянган төгрөгийг хэмнэж 2024 онд 624,551.2 мянган төгрөгийг зарцуулж 113,668.3 мянган төгрөгийн хэмнэлттэй байгаа нь зарим сард орон тоо гүйцэд биш ажилласнаас шалтгаалсан байна.

2. **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал:** 2023 онд 41,180.8 мянган төгрөг батлагдсанаас гэрэл цахилгааны зардал 6,992.7 мянган төгрөг, түлш халаалтын зардалд 42,712.3 мянган төгрөг, цэвэр бохир усны зардалд 1,300.8 мянган төгрөг зарцуулж, 2,000.0 мянган төгрөгийн хэмнэлттэй, 2024 онд 54,241.7 мянган төгрөг батлагдсанаас гэрэл цахилгааны зардал 8,178.9 мянган төгрөг, түлш халаалтын зардалд 40,695.5 мянган төгрөг, цэвэр бохир усны зардалд 1,200.8 мянган төгрөг зарцуулж, 4,166.5 мянган төгрөгийн хэмнэлттэй байна.
3. **Хангамж бараа материалын зардал:** 2023 онд хангамж, бараа материалын зардалд 22,101.4 мянган төгрөг батлагдсанаас бичиг хэргийн зардалд 1,360.6 мянган төгрөг, тээвэр шатахууны зардалд 10,200.0 мянган төгрөг, шуудан, холбоо, интернетийн зардалд 2,711.6 мянган төгрөг, бага үнэтэй түргэн элэгдэх зардалд 1,449.4 мянган төгрөг зарцуулж 6,379.9 мянган төгрөгийн хэмнэлттэй, 2024 онд хангамж, бараа материалын зардалд 32,711.2 мянган төгрөг батлагдсанаас бичиг хэргийн зардалд 3,846.5 мянган төгрөг, тээвэр шатахууны зардалд 20,680.0 мянган төгрөг, шуудан, холбоо, интернетийн зардалд 3,099.0 мянган төгрөг, бага үнэтэй түргэн элэгдэх зардалд 2,484.3 мянган төгрөг зарцуулж 2,601.4 мянган төгрөгийн хэмнэлттэй байна.
4. **Нормативт зардал:** 2023 онд 512.4 мянган төгрөг батлагдаж 270.0 мянган төгрөг зарцуулж, 242.4 мянган төгрөг хэмнэж, 2024 онд 581.1 мянган төгрөг батлагдаж 100 хувь зарцуулжээ.
5. **Эд хогшил, урсгал засварын зардал:** 2023 онд 26,131.3 мянган төгрөг батлагдаж хөдөлмөр хамгааллын хэрэгслийн зардалд 661.5 мянган төгрөг, урсгал засварын зардалд 5,491.0 мянган төгрөг зарцуулж, 19,978.8 мянган төгрөг хэмнэж, 2024 онд 15,355.0 мянган төгрөг батлагдаж, багаж техник хэрэгслийн зардалд 1,880.0 мянган төгрөг, хөдөлмөр хамгааллын хэрэгслийн зардалд 618.3 мянган төгрөг, урсгал засварын зардалд 9,375.7 мянган төгрөг зарцуулж, 3481.0 мянган төгрөгийг хэмнэжээ
6. **Томилолтын зардал:** 2023 онд 4,957.2 мянган төгрөг батлагдаж 4,077.9 мянган төгрөгийг зарцуулж, 879.3 мянган төгрөгийн хэмнэлттэй, 2024 онд 6,637.6 мянган төгрөг батлагдаж 6,350.2 мянган төгрөг зарцуулж 287.4 мянган төгрөгийг хэмнэж ажилласан байна.
7. **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж:** 2023 онд 17,312.1 мянган төгрөг батлагдсанаас 12,597.0 мянган төгрөг зарцуулж 4,715.1 мянган төгрөг хэмнэсэн, 2024 онд 47,160.7 мянган төгрөг батлагдаж 19,168.1 мянган төгрөг зарцуулж 27,992.6 мянган төгрөг хэмнэсэн байна.
8. **Бусад зардал:** 2023 онд 68,920.4 мянган төгрөг батлагдаж 39,817.6 мянган төгрөг зарцуулж 29,102.8 мянган төгрөгийн хэмнэлттэй, 2024 онд 57,905.4 мянган төгрөг батлагдаж бараа үйлчилгээний бусад зардалд 40,872.9 мянган төгрөг, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд 967.2 мянган төгрөг зарцуулж, 16,065.3 мянган төгрөг хэмнэсэн байна.
9. **Урсгал шилжүүлгийн зардал:** 2023 онд зардал төсөвлөөгүй учраас ажил гүйлгээ гараагүй байна. 2024 онд Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг 21,720.0 мянган төгрөг батлагдаж 21,556.7 мянган төгрөг зарцуулж, 163.3 мянган төгрөг хэмнэжээ.

2.2.3 Нэмэлт санхүүжилтийн дансанд: Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчаас 2,993.7 мянган төгрөг, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 1,435.0 мянган төгрөг зэрэг нийт 4,428.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн байна.

Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардалд 1,134.0 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 2,664.4 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 630.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

2.3. Ажилтан албан хаагчдын цалин хөлсний тогтоолт, тооцоололт, олголтын байдал

Сумын ЗДТГ-ын Ажилтан албан хаагчдын цалин хөлсний тогтоолт, тооцоололт, олголтын байдлын тушаал шийдвэр, цагийн тооцоо, цалингийн нэгдсэн систем, холбогдох бусад баримт материалтай тулган шалгахад 2023 онд цалингийн зардлын төсвийг үндэслэлгүй төлөвлөж урамшуулал, гэрээт ажилтны цалингийн зардлыг зардлын эдийн засгийн ангиллаар батлаагүй, үндсэн цалин нэмэгдэл цалингийн зардлаар баталснаар төсвийн хуваарь төлөвлөгдөөгүй 48,154.2 мянган төгрөгийн, 2024 онд 11,580.3 мянган төгрөгийн урамшууллын зардалд гүйцэтгэлээр тайлагнагдсан байна.

Албан хаагчдын үр дүнгийн мөнгөн урамшууллыг ажлын гүйцэтгэл үр дүнтэй уялдуулалгүйгээр нэгэн адил хувь хэмжээгээр олгосон зөрчил дутагдал хяналт шалгалтын явцад тогтоогдсон.

2.4 Орон нутгийн өмчийн хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалт

Орон нутгийн өмчийн хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт хэвийн боловч үндсэн хөрөнгийн данс бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийг хөтлөх заавар аргачлал, бодлогын баримт бичигт тусгасан арга зүйгээр үндсэн хөрөнгийн ангилал, нэршлийг үнэн зөв хөтлөхгүй байгаа нь санхүүгийн тайлан, мэдээлэл буруу илэрхийлэгдэх, хөрөнгөд бүртгэлээр тавих хяналтыг сулруулж байна. Иймд дээрх бүртгэлийн алдааг залруулж бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

Гурав. Шалгалтаар тогтоогдсон нөхцөл байдал, илэрсэн зөрчил дутагдал

Орхонтуул сумын ЗДТГ-ын 2023, 2024 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар хууль тогтоомжийн хэрэгжилт, төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, цалин хөлсний тооцоололт, бараа материал, үндсэн хөрөнгийн бүртгэл

хөтлөлт, засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалт, анхан шатны баримтын бүрдүүлэлт хангаагүй зэрэг дараах зөрчил, дутагдал илэрлээ. Үүнд:

Илрүүлэлт 1. Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийн судалгаа, тооцоог гарган өмч хамгааллын байнгын зөвлөл болон ОНӨГ-ын шийдвэрээр дахин үнэлэх буюу бүртгэлээс хасах зэрэг арга хэмжээ аваагүй тээврийн хэрэгсэл зэрэг нийт 169,125.0 мянган төгрөгийг тайланд тусгасан байна.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх "үнэн зөв байх", 5.1.5 дах "хэмжигдэхүйц байх", 20.2.4, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан журмын 7.1 дэх "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Үндсэн хөрөнгийн элэгдлийг тооцож судалгааг гарган дахин үнэлэх шаардлагатай хөрөнгүүдийг холбогдох шатны байгууллагаар шийдвэрлүүлж алдааг залруулах албан шаардлагыг хүргүүлэв.

Илрүүлэлт 2. Цалингийн зардлын төсвийг үндэслэлгүй төлөвлөж урамшууллын зардлыг зардлын эдийн засгийн ангиллаар батлаагүй, үндсэн цалин нэмэгдэл цалингийн зардлаар баталснаар төсвийн хуваарь төлөвлөгдөөгүй 11,580.3 мянган төгрөгийн зардлын гүйцэтгэл тайлагнасан байна.

Энэ нь төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх "... төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална: 5.1.2.төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", 22 дугаар 22.1 дэх "Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана", 1 дүгээр зүйлийн 41.2.2 дах "Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралт "Эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ын эдийн засгийн ангиллыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нэмэгдэл цалин, гэрээтийн цалингийн зардлыг эдийн засгийн ангиллын дагуу зөв төлөвлөж батлуулах албан шаардлага хүргүүлэв.

Дөрөв. Дүгнэлт, шийдвэрлэлт:

4.1 Дүгнэлт:

Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын даргын баталсан удирдамжаар Орхонтуул сумын ЗДТГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтад хамрагдсан хугацааны төсөв, санхүүгийн гүйцэтгэл, бүртгэл тайлагналт, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үйл ажиллагаанд хийсэн эрсдэлийн үнэлгээгээр "Дунд" эрсдэлтэйд тооцож, төсвийн сахилга бат, үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай гэж дүгнэлээ.

4.2 Шийдвэрлэлт:

Орхонтуул сумын ЗДТГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар нийт **180,705.3** мянган төгрөгийн **2** зөрчил илэрснээс санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагчийн зөрчлийг таслан зогсоох **180,705.3** мянган төгрөгийн **2** албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Тав. Цаашид авах арга хэмжээний санал, зөвлөмж:

Шалгалтын явцад тус байгууллагын дарга, нягтлан бодогч, шалгалтаар илэрсэн зөрчилд хамаарал бүхий холбогдох албан хаагчтай уулзаж асуулга, тодруулга авч Захиргааны ерөнхий хуулийн дагуу сонсох ажиллагаа явуулсан болно.

Шалгалтаар илэрсэн зөрчилт үйлдлүүд нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах нөхцөл болох тул холбогдох хууль тогтоомжуудын хэрэгжилт, тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журмыг ханган ажиллах шаардлагатай байгааг тус сумын ЗДТГ-ын дарга, нягтлан бодогч, бусад холбогдох ажилтнуудад танилцуулж, зөвлөмж өгч шалгалтаар илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй ажиллахыг анхаарууллаа.

Санхүүгийн хяналт шалгалтын тэмдэглэлд тусгагдсан зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийн тайланг нотлох баримтын хамт 2025 оны 12 дугаар сарын 30-ны дотор Санхүүгийн хяналт, дотоод аудитын газарт албан бичгээр ирүүлэхийг тус сумын ЗДТГ-ын дарга, нягтлан бодогч нар т хариуцуулав.

БИЧСЭН.

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ДОТООД
АУДИТЫН ГАЗРЫН САНХҮҮ
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН
АХЛАХ БАЙЦААГЧ



Т.МӨНХЗУЛ

ТАНИЛЦСАН.

ОРХОНТУУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

Д.МЭНД-АМАР

НЯГТЛАН БОДОГЧ

Б.ХОРОЛСҮРЭН

